

Төслийн нэр: "Ухаалаг богц"

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Баян-Өлгий
Сум /дүүрэг: Өлгий
СЭЭБХ-ны хаяг: ЕБ-ын 4 дүгээр Бүрэн Дунд Сургууль
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Хусайн овогтой Замзагүл

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
Давуу тал <ul style="list-style-type: none"> Багш нарын заах аргагүй болон багшлах арга барил сайн. Хүн бүрт ээлтэй сургуулийн орчинтой бүхий талын оролцоог дэмждэг болно. Багш нар хоорондоо мэдээллээ солилцох, асуудлаахэлэлцэж, шийдлээ хамтарч тодорхойлно. Хамтын шийдвэртээ хамтын хариуцлага хүлээж, багийн гишүүн бүр хариуцлагатай байх СЭЭБХ-ийн зарчмыг баримталдаг. 	Сул тал <ul style="list-style-type: none"> Хэрэглэгдэхүүн тус бүрийг хүүхдийн тоогоор бэлдэх боломж хомс. Хичээлээс гадуурхи янз бүрийн дугуйлан явуулах Сурах бичгийн мэдээлэл хомс ойлгоход бэрх уялдаа холбоо бага. Багш нарын асуулгыг багцлан үзэхэд сурах бичгийн, хэрэглэгдэхүүний асуудал 40%, сургалтын орчин 20%, сургалтын чанарын талаар 30%, эцэг эхчүүдийн талаар 10% саналуудыг тус тус оруулж иржээ. Харин эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг сургууль, багш нарын асуудлыг 60% нь, 20% нь сурах бичгийн асуудал, 20% нь эцэг эхчүүдийн талаар 10%-ийг тусгажээ.
Гадаад хүчин зүйлс	
Боломж <ul style="list-style-type: none"> Бага боловсролын багш нарыг дэмжин оролцуулах. Анги болон хичээл хоорондын залгамж чанарыг харгалзах. Харилцан бие биеэ хүндэтгэн, хүн бүр нээлттэй, идэвхтэй оролцдог орчныг бүрдүүлдэг. Эхлээд тоог таниад, дараа нь тэр тооны бүтцийг судлах гэсэн дарааллаар төлөвлөх нь зөв байдаг. 	Эрсдэл <ul style="list-style-type: none"> 6 настангууд хүртэж байж ойлгодог учир тэр болгон олон зүйлийг хүүхэд тус бүрт бэлтгэх нь багшид хүндээр тусдаг. Ангид хүүхдийн тоо их. Сургуулийн удирдлага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар шүүмжлэх бус асуудлын шийдлийг бүтээлчээр олохыг зорьдоггүй. Эцэг эх хүүхдийнхээ хичээлд анхаарал хандуулж туслах боломж, мэдлэг чадвар, цаг хугацааны хувьд хомс байдаг.

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Төслийн зорилго	Ухаалаг богц боловсруулж, эцэг эхэд түгээн бага ангийн сурагчдын математикийн хичээлийн чанарыг дээшлүүлнэ.
Хамрах хүрээ	Бага боловсролын 571 суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бага боловсролын 20 багш

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах	СЭЭБХ-ийн удирдах зөвлөл	11 сарын эхний 7 хоног	Бага боловсролын сургалтын чанарыг ахиулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд

	(Эцэг эх,асран хамгаалагч,харгалзан дэмжигч болон багш нар)	БАЗАН-ын Нэгдэл		гарч буй бэрхшээлийг илрүүлэх
2.	Төслийн нээлт	Сургуулийн удирдлага СЭЭБХ-ийн УЗ	09сарын эхний долоо хоног	БСУГ болон аймгийн удирдлагудыг урина. СЭЭБХ-ны үйл ажиллагааг танилцуулах, төслийн үр дүнд гарах сайн туршлагыг аймгийн хэмжээнд түгээх нөлөөллийн ач холбогдолтой.
I.“Ухаалаг богц” боловсруулах, ашиглах, түгээх хүрээнд				
3.	“Ухаалаг богц” боловсруулах баг гаргах	СЭЭБХ	09 сарын 20	Зөвлөх багш болон БАЗАН-ийн багш нарын төлөөлөөс 3-5 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлнэ.
4.	“Ухаалаг богц”-ын агуулга боловсруулах <ul style="list-style-type: none"> • 1-р ангийн эцэг эхэд зориулсан богц • 2-р ангийн эцэг эхэд зориулсан богц • 3-р ангийн эцэг эхэд зориулсан богц • 4-р ангийн эцэг эхэд зориулсан богц • 5-р ангийн эцэг эхэд зориулсан богц 	Хариуцсан баг	10 сарын 1,2 долоо хоног	Бүлэг бүрийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон агуулга бүхий богцыг боловсруулан хичээл эхэлмэгч ашиглахад бэлэн болсон байна. <ul style="list-style-type: none"> • Математикийн хичээлийн гэрийн даалгавар хийлгэх зөвлөмж – CD хэлбэрээр • Богц агуулгыг ашиглах заавар • Өдөр бүр гэрийн даалгавар хийлгэсэн байдлаа тэмдэглэх хуудас • 7 хоног бүрээр ахицаа үнэлэх хуудас богц дотор заавал багтана.
Ухаалаг богц доторх үндсэн агуулга:				
<ul style="list-style-type: none"> • 1-р анги:1-100 хүртэлх тоолох,бичих,нэмэх хасах,тэгш сондгой тоог таних,хос хэлээр тоолох нь • 2-р анги:Дүрсийн нэрийг хос хэлээр нэрлэх, юмсыг багцлан тоо хэмжээг олох,үржүүлэх,үйлдлийн холбоог олох,хүрдийг энгийн аргаар тогтоох нь • 3-р анги:1000 доторх тоог нэмэх,хасах,аравт,зуут тэдгээр ойр тоог цээжээр үржүүлэхийн хүрдийг хэрэглэн тоог нэгжээр,10-аар,100- аар үржүүлэх,1Е-т 100-д хуваах нь • 4-р анги: Үржүүлэх хүрд болон тооны 2,4,5,10,25,100 шинжийг мэдэх,цээжээр тооцоолоход хэрэглэх,10-д ойр 2 оронтой тоог цээжээр үржүүлэх,үржвэрийн утга • 5-р анги: 2 оронтой тоог 2 буюу хэд хэдэн тооны үржвэр хэлбэртэй болгох,хэдэн тооны ерөнхий хуваагч,ерөнхий хуваагдагчийг олох 				
5.	“Ухаалаг богц” хэрхэн ашиглах талаар видео заавар боловсруулах	Зөвлөх баг, СЭЭБХ	02 сарын 8-15	Эцэг эхэд зориулсан сургалтад ашиглах богц дотор хамт аялуулах зөвлөмж бүхий CD хичээл бэлэн болсон байна.
6.	“Ухаалаг богц” ашиглах нь багш нарт зориулсан сургалт	Зөвлөх багийн гишүүд, СЭЭБХ	02 сарын гурав дахь долоо хоног	Бага ангийн багш нар ухаалаг богц хэрхэн ашиглах талаар мэдлэгтэй болсон байна. Өерин хариуцсан ангийн эцэг эхэд ашиглах арга зүйг заахад бэлэн болсон байна.

7.	“Ухаалаг богц” ашиглах арга зүй эцэг эхэд зориулсан сургалтыг үе шаттай зохион байгуулах	Анги удирдсан багш нар, СЭЭБХ	02 сарын 25 03 сарын 05 дотор	Бүх эцэг эх ухаалаг богцыг гэрээр ашиглах талаар мэдээлэлтэй болсон байна.
8.	Анги удирдсан багш нарт “Хэрэглэгдэхүүн ашиглалтын карт” хэвлүүлэн тарааж, гэрээ хийх	СЭЭБХ-ны гишүүд, Номын санч	Жилийн турш	Богц доторх хэрэглэгдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилготой. Хичээл амрахаас өмнө буцааж авахад богц бүрэн байхад энэхүү гэрээг ашиглах юм.
II. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд				
9.	“Ухаалаг богц” миний туслах хэлэлцүүлэг зохион байгуулах <ul style="list-style-type: none"> • 1-р ангийн эцэг эхчүүд • 2-р ангийн эцэг эхчүүд • 3-р ангийн эцэг эхчүүд • 4-р ангийн эцэг эхчүүд • 5-р ангийн эцэг эхчүүд 	СЭЭБХ, БАЗАН	3-р сарын сүүлийн долоо хоног	Ухаалаг богцыг ашиглан хүүхдийнхээ гэрийн даалгаварыг хийлгэхэд тулгарсан бэрхшээл, ололт амжилтын тухай хэлэлцэнэ. Ухаалаг богцыг эцэг эхчүүдэд хэрхэн өргөн хүрээтэй ашиглуулах тухай хэлэлцэнэ.
10.	Зочинтой ярилцлага зохион байгуулах	СЭЭБХ	2 сард нэг удаа	Хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг ойлгох, гэрийн даалгавар хийлгэхэд анхаарахад чиглэсэн ярилцалгууд байна.
11.	“Шилдэг эцэг эхийн оролцоотой” анги хамт олныг урамшуулах <ul style="list-style-type: none"> • Ухаалаг богцоо хамгийн сан ашигласан • Гэрийн даалгавраа тогтмол хамт хийсэн • Сурлагын амжилт гаргасан зэрэгг шалгуураар 	СЭЭБХ, Сургуулийн удирдлага	4сарын 2 дахь 7хоног	Ухаалаг богцыг хамгийн сайн ашигласан эцэг эхийг шалгаруулах ба хамгийн олон эцэг эх шалгарсан ангийг “Шилдэг эцэг эхийн оролцоотой анги”-аар өргөмжлөх
III. Төслийн тогтвортой байдлыг хангах хүрээнд				
12.	СЭЭБХ-ны удирдах зөвлөлийн уулзалт	Удирдах зөвлөлийн гишүүд, аудит, санхүүч	Улиралд 1 удаа	Төслийн багийн зүгээс танилцуулсан төслийн үйл явцын мэдээллийг авч, сайжруулах зөвлөгөөг тогтмол өгнө.
13.	Төслийн багийн уулзалт	СЭЭБХ, Зохицуулагч	2 сард 1 удаа	Төслийг улам сайжруулж боловсронгуй болгоно. Ажил үүргийн хувиар гаргана.
14.	Төслийн хаалт	СЭЭБХ-ны гишүүд, Сургуулийн удирдлага	2020.05.10	Аймгийн БСУГ-ын дарга, мэргэжилтэнгүүд, Сургуулийн удирдлага захирал, нийгмийн ажилтан,бага, дундын сургалтын менежерүүд, эцэг эхийг урина. Төслийн амжилт, үр дүнгээ танилцуулна.

Хэсэг IV.Зардлын задаргаа

Үйл ажиллагааны зардал	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ,төг	Үр дүн
Төслийн нээлтийн үйл ажиллагаа	ш	100	1000	50 000	Төслийн нээлтийн үйл ажиллагааны цайны материал авна.
Баннер хэвлүүлэх	Ш	1	50000	50 000	Төслийн турш ашиглах баннер хийлгэнэ.
Зөвлөх багийн уулзалтын зардал	Удаа	5	20000	100 000	Ухаалаг богц боловсруулна.
Зөвлөх багийн урамшуулал	Хүн	5	100 000	500 000	Ухаалаг богц боловсруулна.
Ухаалаг богц ашиглах заавар видео хичээл хийлгэх <ul style="list-style-type: none"> • Видео бичүүлэх • Монтажлах 				400 000	Ухаалаг богц дотор дагалдах видео хичээл бэлэн болно.
Видео хичээлийг богц бүрийн тоогоор хувилах	ш	200	1000	200 000	Ухаалаг богц дотор дагалдах видео хичээл бэлэн болно.
Ухаалаг богц ашиглах багш нарт зориулсан сургалт зохион байгуулах	Хүн 1 удаа	25	2000	50 000	Сургалтын цайны материал авна.
Ухаалаг богц ашиглах нь эцэг эхэд зориулсан сургалт зохион байгуулах	Хүн	500	1000	500 000	Анги бүрийн эцэг эх “Ухаалаг богц” ашиглах арга зйг эзэмшинэ.
Ухаалаг богц миний туслах хэлэлцүүлэг зохион байгуулах	Удаа	5	50000	250 000	1-5 р ангийн бүлэг бүрт нэг удаа зохион байгуулна.
Зочинтой ярилцлага Зочны урамшуулал Цайны материал	Удаа	4	70 000 30 000	400 000	Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар гэрийн даалгавар хийлгэх, хүмүүжлийн эерэг арга зэрэг эцэг эхэд хэрэгтэй мэдээллийг мэргэжлийн хүнээс авна.
“Шилдэг эцэг эхийн оролцоотой анги” шалгаруулах “Ухаалаг богц”- оо хамгийн сайн ашиглаж сурлагын амжилт гаргасан анги, эцэг эхийг шалгаруулж урамшуулна.	Удаа	1	150 000	150 000	Эцэг эхийг урамшуулна. Гарсан өөрчлөлтийг сургуулийн хэмжээнд сайн туршлага болгон түгээнэ.
“Ухаалаг богц” зарим доторх хэрэглэгдэхүүний худалдан авалт	ш	200	4000	800 000	Ухаалаг богц доторх багц бэлэн болно.
Өнгөт принтер	ш	1	500 000	500 000	Төслийн хүрээнд зохион

Картридж		2	80000	160 000	байгуулах уулзалт, хэлэлцүүлэг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад ашиглах, ухаалаг богц дотор зарим хэрэглэгдэхүүнийг боловсруулна.
Хор		4	30000	120 000	
Ламинатор цаас	боодол	2	40000	80 000	
Бичгийн цаас А4	боодол	10	11000	110 000	
Бичгийн цаас А3	боодол	3	19000	57 000	
Ламинатор аппарат	ш	1	100000	100 000	
Замын зардал		2	172000	344 000	
Ачааны хөлс	кг	100	1000	100 000	
Банкны шимэтгэл				20 000	
Нийт дүн			5 151 000₮		

Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

Чадавхийн бэхжилт	Тогтвортой байдал
Математикийн дугуйлан, сургалтын хэрэглэгдэхүүний чанар, нөөц, төрөл нэмэгдсэнээр суралцагчид мэдээлэл хайх, цуглуулах, боловсруулах, чадвараа хөгжүүлэн хүүхэд бүрийн хөгжлийг дэмжинэ.	Төсөл хэрэгжиж дууссаны дараа сургуулийн суралцагч бүр тоолох, олон оронтой тоог унших, бичих, цэгээртэмдэглэх, жиших, тоймлох, хэмжэг дэхүүнийг ойлгох, дүрс биетийг судлах зэрэг чадваруудыг биет үзүүлэнгүүдээр хийх. Суралцагчид эх хэл, математик сэтгэлгээний чадварыг нэмэгдүүлэхэд интернет болон багш нарын боловсруулсан хичээлээ төрөл бүрээр хөгжихүйлийн орчин бүрдүүлнэ.
Эцэг эх математик хэлээр харилцахад тус дөхөм болно. Тухайлбал: нэмэгдүүлэх, хорогдуулах, том, жижиг, урт, богино, хүнд, хөнгөн, гурвалжин, дөрвөлжин, дугуй, илүү дутуу, их, агуулгатай холбоотой үзүүлэн, хэрэглэгдэхүүн \үржүүлэхийн гэх мэт\ нэгж квадрат, шооны загвар, бага, нэмэгдэхүүн, нийлбэр, хасагдагч, хасагч, ялгавар, зөрөө, нийт, нийлээд, багтаамж гэх мэт олон шинэ үгтэй	Эцэг эх математикийн хичээлийн үнэ цэнийг ойлгох. Багш суралцагчдад, суралцагч – суралцагчдадаа, эцэг эх-багш, багш-эцэг эхдээ мэдээлэл дамжуулах, цахим хэрэглэгдэхүүн хүртээмжтэй байж, хүүхдийн хэл сэтгэлгээг хөгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх замаар олон талт чадвар нь хөгжснөөр хүүхдийн бүхий л чадварт ахиц бий болно. Хүүхдээс хүүхдээс рүү сурах арга зүйд сургах.
Сайн туршлага болгон хичээлийг үр өгөөжтэй явуулах арга зүйг боловсруулж цаашид хичээлийг энэ аргазүйд тулгуурлан явуулах. Сургалтын хэрэглэгдэхүүн, цахим хичээлээр дамжуулан багш хөгжих боломж бий болж, сургалтын чанарт ахиц гаргана. Анги бүрийн залгамж холбоог хангаж, математикийн агуулгыг бүхэлд нь харах боломж олгож байна.	Багшийн ажлын ачааллыг багасгана. Багшийн хувьд суралцагчийг хөгжүүлэх зорилгоор багш сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэхдээ сурах бичиг, зөвлөмжөөс гадна бусад хэрэглэгдэхүүн \тарааж өгөх материал, багаж хэрэгсэл гэх мэт\ сургалтын үндсэн хөтөлбөрийн үзэл санаанд нийцэх арга барил, хэлбэр, хэрэглэгдэхүүний олдоц, хийх бэлтгэх боломж зэрэг нь нээлттэй болно. Эцэг эхийн оролцоо бодитойгоор нэмэгдэн хамтран ажиллахад дөхөм болно.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

СЭЭБХ-ны Зохицуулагч: Х.Замзагүл

/Гарын үсэг.....*Х.Замзагүл*...../

Төслийг
боловсруулсан:

Эцэг эх	<i>М. Аршагүл</i>	М.Алмагүл
Эцэг эх	<i>С. Нургүл</i>	С.Нургүл
Эцэг эх	<i>Т. Манар</i>	Т.Манар
Эцэг эх	<i>Д. Лаззат</i>	Д.Лаззат
Багш	<i>Ж. Аршагүл</i>	Ж.Аршагүл
Багш	<i>Б. Ёлка</i>	Б.Ёлка
Багш	<i>А. Аххайын</i>	А.Аххайын
Багш	<i>М. Жангүл</i>	М.Жангүл

Огноо:

2018 он *12* сарын *03* өдөр

ДӨРӨВДҮГЭЭР
СҮРГУУЛЛИН
ЭЦЭГ ЭХ, БАГШЛИН
ХОЛЗОО ТӨӨ
ТАМГА